



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 03 дугаар сарын 23 өдөр

Дугаар 25

Хэрлэн сум

XXV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 25 дугаар хуралдаан 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 13:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 78,2 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

- 1.Гэрийн ажиглалтын явцын талаар мэдээлэл танилцуулах,
Эрүүл мэндийн газар
- 2.Хүмүүнлэгийн тусламжийн талаарх мэдээлэл танилцуулах, сумдын Онцгой комисст хүмүүнлэгийн тусламжаас дэмжлэг үзүүлэх эсэх талаар хэлэлцэх,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар
- 3.Малын эмч нарын сургалт, семинар зохион байгуулахыг зөвшөөрөх эсэх талаар хэлэлцэх,
Мал эмнэлгийн газар
- 4.Аймгийн Онцгой комисст иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудаас ирүүлсэн хүсэлт, албан бичиг танилцуулах,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.1.Халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор нэг удаагийн амны хаалтыг аймгийн төвөөс бусад сумдын Ерөнхий боловсролын сургуульд 2000 ширхэг, Цэцэрлэгт 1000 ширхэг, Эрүүл мэндийн төвд 1000 ширхэгийг тус тус олгох, Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас нийт 52,000 ширхэгийг 13 сумын Онцгой комисст олгохыг зөвшөөрөв,

Хоёр.Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа-д:

2.1.Дорнод аймгийн Хувийн хэвшлийн малын эмч нарын нэгдсэн сургалт зохион байгуулах ажлын хэсгийг 13 сумдад томилж, халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлэн хяналт тавьж ажиллахыг зөвшөөрөв,



/ Ч.Ганбат

/ Д.Баттулга

Гурав.Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Д.Мөнхтуяа,
Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын
гишүүн Ц.Мөнхтөр нарт:

3.1.“Хан цайз” ХХК-аас аймгийн Онцгой комисст ирүүлсэн “Карго үйлчилгээний 2 тээврийн хэрэгслийн нэмэгдүүлэх тухай” хүсэлтийн дагуу Мэргэжлийн хяналт, Авто тээврийн улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэж шийдвэрлэхийг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ
КОМИССЫН ОРЛОГЧ ДАРГА  Ч.ГАНБАТ

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА